## МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛЫН ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР

Хувилбар А

Хугацаа-60 минут Нийт-20 оноо

1. Эхийг анхааралтай уншиж ойлгосны дараа даалгавруудыг гүйцэтгээрэй.
2. Сонгох даалгаврын зөвхөн нэгийг нь л сонгоорой

Уран Гомбожав

Эрт цагт Гомбожав гэгч нэг уран хүн байж гэнэ. Нэгэн харамч баян Гомбожаваар гэрийн хаалга хийилгэхээр хэлэлцжээ. Харамч баян хөлс хайрлахгүй өгнө гэсэн болохоор Гомбожав их л сайхан хаалга хийгээд, хэзээ авахыг нь хүлээв.

Тэгтэл өнөөх баян нэг өдөр Гомбожавт шүдлэн хонь хүргүүлж, хаалгаа нэхжээ. Гомбожав хаалгыг нь хийчхээд байсан боловч “Маргааш ав” гээд өгсөнгүй. Дараах өдөр нь Гомбожав хаалгыг нь урьд захиж хийлгэсэн хоёр домбоны нь хамт баяныд явуулжээ.

Баяных шинэ нутагт бууж, өнөөх сайхан хаалгаа барьчхаад тун баяртай байв. Гэтэл хаалга нь хаах онгойлгох бүр “Уран Гомбожавын хийсэн хаалга, хөлс нь дэндүү багадсан хаалга” гэж дуугараад байжээ. Хоёр домботой цайнаас нь аягалахаар “Боль, боль” гэж дуугараад аяга дүүрч өгөхгүй байж гэнэ.

1. А. Гомбожав яагаад “Маргааш ав” гэж буцаасан бэ? **1 оноо**

А. Хаалга бэлэн болоогүй учир Б. Домбо нь бэлэн болоогүй учир В. Завгүй байсан учир Г. Хөлс нь багадсан учир

Б. Эхэд юун тухай өгүүлж байна вэ? **1 оноо**

А. Харамч баяны тухай Б. Уран гартай хүний тухай В. Хүний хөдөлмөрийг хүндэтгэх тухай Г. Хаалга, домбо дуугарсан тухай

2. Зөв харгалзуулаарай. **2 оноо**

| | |
|---|---|
| А. хүн, баян, барьчхаад | 1. Тэмдэг нэр, үйл үг, нэр үг |
| Б. Харамч, онгойлгох, хаалга | 2. Нэр үг, тэмдэг нэр, үйл үг |
| В. Домботой, сайхан, дуугараад | 3. Нэр үг, тэмдэг нэр, үйл үг |

3. .Цэгийн оронд тохирох нөхцөлийг нөхөж бичнэ үү. **2 оноо**

Нүүдэлчин монголчууд галаа тойрон сууж, эргэ... хорвоо... элдэв явдал... хүүрнэн ярь... байсан нь тэдэнд эрүүлж... увдис... заяаж байжээ.

Нөхөх нөхцөлүүд: -ыг, -даг, -х, -ийн, -х, -ыг

4. Дараах хэсгүүдийг зөв харгалзуулаарай. **2 оноо**

| | |
|---|---|
| **А.** жинчид, зулзагыг | 1. Биед хамаатуулах нөхцөл, заахын тийн ялгал |
| Б. Могой, тэмээний | 2. Нэрлэхийн тийн ялгал, харьяалахын тийн ялгал |
| В. Элэг нь, түүнийг | 3. Олон тооны дагавар, заахын тийн ялгал |

5. Дараах үгсээс зөв бичсэн үгийг сонгон дугуйлаарай. **2оноо**

| | | |
|---|---|---|
| А.1.буц+я=буцъя | 2.буц+я =буцая | 3.буц+ь=буцья |
| Б.1.тавь+саар=тависаар | 2.тавь+саар=тавьсаар | 3.тавь+саар=тавсаар |
| В.учир+ыг=учирыг | 2.учир+ыг=учрыг | 3.учир+ийг=учрийг |

6. А. Үндэсний бичгээс кирилл бичигт хөрвүүлэн бичээрэй. **2 оноо**

[illegible] ..........................................................................................

**6.** Б. Кирилл галигаас үндэсний бичигт буулгаад, кирилл бичигт хөрвүүлээрэй. **3 оноо**

Дусал – и хурийавал далаи.........................................................................................

Дугулугсан- и хурийавал эрдэм.................................................................................

Эрдэм-и хичийэл-ийэр сурдаг.....................................................................................

Эрил-и сураг-ийар олдог..............................................................................................

.......................................................................................................................................

.......................................................................................................................................

.......................................................................................................................................

...................................................................................................................

**7.** Зохиолын хэсгийг зохиолын нэртэй нь харгалзуулаарай. **5 оноо**

| | |
|---|---|
| 1. Хэрэв жолоочийн хажууд суугч тамхиа ноцоох<br>хэрэг гараагүй бол шаргачин эх үр хоёр<br>гашуун зовлонд учралгүй өнгөрч болох байсан билээ” | А. Хүүхдийн бор |
| 2. Дүүжүү алсаас ирээд<br>Дүүрэн амьсгаа авахад минь<br>Мөнхийн уснаас амсах шиг<br>Цээж дүүрэн цэлмээд | Б. Аранзал зээрд |
| 3. Хайр чулуу<br>Арван зүгтээ<br>Арван зүгтээ<br>Цацагдана. | В.Шаргачин |
| 4. Өнгөрөөд явчих вий гэж<br>Ээж гэртээ сандарна.<br>Өрөм зөөхийд хөөрцөглөж<br>Хийц амтыг нь болгооно. | Г.нүүдлийн цай |
| 5. “...Зуны нозоором халуунд бид зургаа<br>Хүйсийн худаг дээр очиж, хүйтэн усаар<br>тоглох гэж бор атаа хэвтүүлээд мордоход | Д. Монголын тал нутаг |

**МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛЫН ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР**

Хувилбар Б

Хугацаа-60 минут Нийт-20 оноо

1. Эхийг анхааралтай уншиж ойлгосны дараа даалгавруудыг гүйцэтгээрэй.
2. Сонгох даалгаврын зөвхөн нэгийг нь л сонгоорой

. Жинчин дагасан могой

Бээжин орохоор говийг туулан жинчид явж байжээ. Нэг өглөө ачаа барааных нь дэргэд нэг могой цагариглан хэвтэж байв. Хэн ч түүнийг сонирхож тоосонгүй. Маргааш нь нэг газар хоноод хөдлөхөд аанай л бас нөгөө могой хэвтэж байв. Хэн ч түүнийг анхаарч үзсэнгүй.

Тав дахь удаа хоноглоод хөдлөх гэж байтал элэг нь улаан нялга болчихсон хөөрхий могой мөлхсөөр орж ирлээ. Хөдлөх гэж байсан жинчид саатаж, тэмээгээ түр хэвтүүлэв. Могой яг л гурав дахь тэмээний хажууд очоод хэвтжээ.

-Энд л нэг учир байна даа гэхэд

-Наадах чинь эх могой байна, үр зулзагыг нь бид ачаандаа оруулжээ гэж хэлсэн юм. Нээрээ л тийм байжээ.

1. **А. Могой яагаад жинчдийн ачаа барааны дэргэд хэвтсэн бэ? 1 оноо**

А. Могойн байрладаг байр учир

Б. Дулаан нөмөртэй байсан учир

В. Үр нь тэнд байсан учир

Г. Жинчдийг бараадсан учир

**Б. Дээрх эхийн сэдвийг зөв тодорхойлсон хэсгийг олоорой. 1 оноо**

А. Могойн тухай Б. Жинчдийн тухай В. Тэмээний тухай Г. Эхийн сэтгэл

2. **Дараах хэсгүүдийг зөв харгалзуулаарай. 2 оноо**

| | |
|---|---|
| **А.** жинчид, зулзагыг | 1. Биед хамаатуулах нөхцөл, заахын тийн ялгал |
| Б. Могой, тэмээний | 2. Нэрлэхийн тийн ялгал, харьяалахын тийн ялгал |
| В. Элэг нь, түүнийг | 3. Олон тооны дагавар, заахын тийн ялгал |

**3.** Дараах өгүүлбэрийг нэр, үйлийн нөхцөлөөр холбож утга төгс өгүүлбэр бүтээнэ үү. **2 оноо**

Сүрэнхүү хурдан хул моринд... ташуур өгөн давхи... Буурал... даваан дээр ирж буу... овоонд чулуу нэмж, алсад харагдах уулсын бараа... ширт... бодлогоширов.

**Нөхөх нөхцөл**: - саар, - оо,-н,-аад, -г, -ын

**4.** Дараах үгсээс зөв бичсэн үгийг дугуйлаарай. **2 оноо**

| | | |
|---|---|---|
| 1.тарь+аа=тариа | 2.тариа+аа =тариа | 3.тарь+иа= тариа |
| 1.өгь+е=өгье | 2.өг+ь = өгье | 3.өг+е=өгье |
| 1.бухал+ыг=бухалыг | 2.бухал+ыг=бухлыг | 3.бухал+ийг=бухлийг |

**5. Бүгд зөв бичсэн хэсгийг олоорой. 2 оноо**

А. Баяний, дүүрж, аягалахаар В. Дуугараад, хийлгэсэн, болохоор

Б. Хаалагаа, Гомбожавын, барьчхаад Г. Баяных, авхыг, домботой

6. Дараах өгүүлбэрийг кирилл бичигт хөрвүүлээрэй. 2 **оноо**

[illegible]

......................................................................................................

......................................................................................................

......................................................................................................

Б. Кирилл галигаас үндэсний бичигт буулгаад, кирилл бичигт хөрвүүлээрэй. **3 оноо**

Олан хүмүн сайин- таи магу-таи

Ои моду урту-таи богуни-таи хэмэхү мэргэн үгэ буи.

..........................................................................................................................................

..........................................................................................................................................

..........................................................................................................................................

..........................................................................................................................................

..........................................................................................................................................

.................................................................

.

7.Зохиолын нэрийг зохиолын агуулгатай зөв харгалзуулна уу? **5 оноо**

1. Л.Одончимэг “Хүүхдийн бор” өгүүллэг — А. Өндөр уулсыг даван, өргөн далай дээгүүр
2. П.Хорлоо “Алт мөнгө хоёр” өгүүллэг — Б. Эрэг номын хааны, эд баялагийн тэнгэр..
3. Лакшмын соёрхол — В. Бүжигчин хүн харвал уран хөдөлгөөний ....
4. Кейко Тани “Цаасан онгоцны үлгэр” — Г. Унтахаар нөмөртэй газар олоод, ахыгаа...
5. Ч.Лодойдамба “Шаргачин” өгүүллэг — Д. Гэтэл манай нутагт нэгдэлжих хөдөлгөөн...